



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: О.Хосбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1 Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	14
3.6.3 Нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага .....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мерен сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/131  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.РАДНААБАЗАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
1728090001 & 3073005

А.ЭРДЭНЭБААТАР

**Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>208,117,985.26</b>	<b>297,770,216.59</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>412,000.00</b>	<b>15,892.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	412,000.00	15,892.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>207,705,985.26</b>	<b>297,754,324.59</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>17,530,800.00</b>	<b>18,340,150.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	16,023,300.00	16,804,350.00
35130	Эм боох материал	1,507,500.00	1,535,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>190,175,185.26</b>	<b>279,414,174.59</b>
35410	Бичиг хэргийн материал	1,396,350.00	1,479,900.00
35420	Аж ахуйн материал	2,707,850.00	2,706,000.00
35440	Түлш, шатах тослох материал	38,688,730.15	21,900,000.15
35450	Барилгын засварын материал	1,540,200.00	2,121,900.00
35460	Хүнсний материал	23,929,068.11	28,991,988.11
35470	Бусад хангамжийн материал	121,912,987.00	222,214,386.33
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>565,772,592.42</b>	<b>575,459,670.50</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>565,772,592.42</b>	<b>575,459,670.50</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>486,909,592.42</b>	<b>496,596,670.50</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	532,489,020.09	321,395,661.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-187,514,822.93	-54,053,870.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,800,000.00	29,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,863,888.91	-12,830,555.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,761,833.20	296,655,198.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,745,771.67	-172,890,699.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,535,957.35	96,214,957.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,883,246.85	-67,953,078.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,491,382.06	59,491,382.06
39215	Хуримтлагдсан элэгдэл	-37,661,101.42	-40,251,237.22
39217	Ном	39,500,231.50	41,018,913.02
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>78,863,000.00</b>	<b>78,863,000.00</b>
39301	Программ хангамж	5,737,000.00	5,737,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,037,000.00	-1,037,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	74,163,000.00	74,163,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>773,890,577.68</b>	<b>873,229,887.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,443,447.00</b>	<b>258,536.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,443,447.00</b>	<b>258,536.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,443,447.00</b>	<b>258,536.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,443,447.00	258,536.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>772,447,130.68</b>	<b>872,971,351.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>772,447,130.68</b>	<b>872,971,351.09</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	450,514,427.06	450,514,427.06
51101	Өмч: - төрийн	450,514,427.06	450,514,427.06
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-123,193,681.01</b>	<b>171,742,689.92</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-123,193,681.01	71,218,469.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	100,524,220.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	445,126,384.63	250,714,234.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>773,890,577.68</b>	<b>873,229,887.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,099,167,293.50</b>	<b>1,224,422,283.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,266,493.50</b>	<b>162,595,243.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,266,493.50</b>	<b>162,595,243.85</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,266,493.50	162,595,243.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,266,493.50	162,595,243.85
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,092,900,800.00</b>	<b>1,061,827,040.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,010,235,700.00	980,161,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>866,100.00</b>	<b>5,489,940.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,929,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	866,100.00	560,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>81,799,000.00</b>	<b>76,175,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,799,000.00	76,175,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,084,181,303.81</b>	<b>1,062,401,169.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,084,181,303.81</b>	<b>1,062,401,169.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,024,296,417.81</b>	<b>1,033,087,801.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>726,963,601.00</b>	<b>738,656,384.00</b>
210101	Үндсэн цалин	726,963,601.00	738,656,384.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,362,253.00</b>	<b>96,282,486.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	62,454,174.00	67,149,270.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,267,609.00	7,383,354.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,814,087.00	5,906,681.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,438,762.00	1,440,290.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,387,621.00	14,402,891.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,999,717.00</b>	<b>79,625,804.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,890,765.00	12,837,074.00
210302	Түлш, халаалт	40,108,952.00	64,788,730.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,006,039.20</b>	<b>21,415,453.00</b>
210401	Бичиг хэрэг	272,100.00	930,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,803,500.00	13,553,615.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	476,500.00	300,500.00
210404	Ном, хэвлэл	764,600.00	706,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,400.00	499,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,239,850.00	2,703,690.00
210408	Бараа материал акталсны зардал	33,949,089.20	2,721,248.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,938,970.00</b>	<b>47,443,450.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,083,700.00	1,277,500.00
210502	Хоол, хүнс	34,855,270.00	46,165,950.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,955,000.00</b>	<b>8,317,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	630,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,325,000.00	8,317,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>112,000.00</b>	<b>707,000.00</b>

210702	Дотоод албан томилолт	112,000.00	707,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>919,550.00</b>	<b>3,585,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	419,550.00	2,985,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,039,287.61</b>	<b>37,053,524.28</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,508,200.00	4,128,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,531,087.61	32,907,074.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,884,886.00</b>	<b>29,313,368.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,253,240.00</b>	<b>29,066,030.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,253,240.00	27,956,030.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,110,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,631,646.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,631,646.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>247,338.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	247,338.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>14,985,989.69</b>	<b>162,021,114.57</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>61,496,894.16</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	61,496,894.16
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-61,496,894.16</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,985,989.69</b>	<b>100,524,220.41</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	-147,779,209.08	747,861,602.61
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,514,427.06	-147,779,209.08	747,861,602.61
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-21,272,789.19	-21,272,789.19
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	-123,193,681.01	772,447,130.68
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	-123,193,681.01	772,447,130.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	194,412,150.52	194,412,150.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,514,427.06	71,218,469.51	966,859,281.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	100,524,220.41	100,524,220.41
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	171,742,689.92	872,971,351.09

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,092,900,800.00</b>	<b>1,061,827,040.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,092,900,800.00</b>	<b>1,061,827,040.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,010,235,700.00	980,161,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>866,100.00</b>	<b>5,489,940.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,929,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	866,100.00	560,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>81,799,000.00</b>	<b>76,175,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,799,000.00	76,175,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,090,950,800.00</b>	<b>1,027,885,440.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,090,950,800.00</b>	<b>1,027,885,440.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,018,657,304.00</b>	<b>996,204,702.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>717,699,154.00</b>	<b>735,251,562.00</b>
210101	Үндсэн цалин	608,970,154.00	487,043,926.00
210102	Нэмэгдэл	50,073,300.00	206,913,086.00
210104	Урамшуулал	58,655,700.00	41,294,550.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,817,400.00</b>	<b>99,291,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	71,431,500.00	69,871,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,346,400.00	7,354,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,877,300.00	5,883,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,469,300.00	1,470,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,692,900.00	14,709,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>75,545,000.00</b>	<b>64,075,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,447,318.00	14,075,600.00
210302	Түлш, халаалт	67,097,682.00	48,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,017,400.00</b>	<b>24,290,100.00</b>
210401	Бичиг хэрэг	726,500.00	872,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	13,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	476,500.00	300,500.00
210404	Ном, хэвлэл	1,161,700.00	721,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,460,400.00	499,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,192,300.00	8,396,900.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>66,554,300.00</b>	<b>50,907,740.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,224,700.00	617,840.00
210502	Хоол, хүнс	28,460,100.00	48,861,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,869,500.00	1,428,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,000,000.00</b>	<b>13,824,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	4,305,000.00

210602	Тавилга	6,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	9,519,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>112,000.00</b>	<b>707,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	112,000.00	707,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>919,550.00</b>	<b>3,585,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	419,550.00	2,985,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,992,500.00</b>	<b>4,271,100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,992,500.00	4,271,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>72,293,496.00</b>	<b>31,680,738.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,661,850.00</b>	<b>31,433,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,414,850.00	30,323,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,247,000.00	1,110,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,631,646.00</b>	<b>247,338.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,631,646.00	247,338.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,950,000.00</b>	<b>33,941,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,950,000.00</b>	<b>33,941,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,950,000.00</b>	<b>33,941,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,950,000.00</b>	<b>33,941,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,950,000.00	33,941,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-1,950,000.00</b>	<b>-33,941,600.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,056,337,100.0	1,056,089,762.0	247,338.0	00.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,056,337,100.0	1,056,089,762.0	247,338.0	00.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,024,903,700.0	1,024,656,362.0	247,338.0	00.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	735,492,300.0	735,251,562.0	240,738.0	00.0
210101	Үндсэн цалин	487,631,200.0	487,043,926.0	587,274.0	00.0
210102	Нэмэгдэл	206,901,100.0	206,913,086.0	-11,986.0	00.0
210104	Урамшуулал	40,960,000.0	41,294,550.0	-334,550.0	00.8

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>				
		99,291,200.0	99,291,200.0	00.0	00.0
210201	Тэтгэврийн даатгал	69,871,700.0	69,871,700.0	00.0	00.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,354,900.0	7,354,900.0	00.0	00.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,883,900.0	5,883,900.0	00.0	00.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,470,900.0	1,470,900.0	00.0	00.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,709,800.0	14,709,800.0	00.0	00.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>				
		64,075,600.0	64,075,600.0	00.0	00.0
210301	Гэрэл, цахилгаан	14,075,600.0	14,075,600.0	00.0	00.0
210302	Түлш, халаалт	48,000,000.0	48,000,000.0	00.0	00.0
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.0	2,000,000.0	00.0	00.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>				
		23,744,200.0	23,744,200.0	00.0	00.0
210401	Бичиг хэрэг	475,700.0	402,700.0	73,000.0	-15.3
210402	Тээвэр, шатахуун	13,500,000.0	13,500,000.0	00.0	00.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	475,700.0	300,500.0	175,200.0	-36.8
210404	Ном, хэвлэл	396,400.0	644,600.0	-248,200.0	62.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	499,500.0	499,500.0	00.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,396,900.0	8,396,900.0	00.0	00.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>				
		50,575,300.0	50,575,300.0	00.0	00.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	285,400.0	285,400.0	00.0	00.0
210502	Хоол, хүнс	48,861,500.0	48,861,500.0	00.0	00.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,428,400.0	1,428,400.0	00.0	00.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>				
		44,409,600.0	44,409,600.0	00.0	00.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,310,000.0	32,310,000.0	00.0	00.0
210604	Урсгал засвар	12,099,600.0	12,099,600.0	00.0	00.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>				
		713,600.0	707,000.0	6,600.0	-00.9
210702	Дотоод албан томилолт	713,600.0	707,000.0	6,600.0	-00.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>				
		1,930,800.0	1,930,800.0	00.0	00.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,330,800.0	1,330,800.0	00.0	00.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.0	600,000.0	00.0	00.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>				
		4,671,100.0	4,671,100.0	00.0	00.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,671,100.0	4,671,100.0	00.0	00.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>				
		31,433,400.0	31,433,400.0	00.0	00.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
		31,433,400.0	31,433,400.0	00.0	00.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,323,400.0	30,323,400.0	00.0	00.0

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,110,000.0	1,110,000.0	00.0	00.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,056,337,100.0	1,056,089,762.0	247,338.0	00.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	980,161,900.0	979,914,562.0	247,338.0	00.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	980,161,900.0	979,914,562.0	247,338.0	00.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	76,175,200.0	76,175,200.0	00.0	00.0
132001	Орон нутгийн төсвөөс	76,175,200.0	76,175,200.0	00.0	00.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	59.00	59.00	00.00	100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	00.00	100
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00	00.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,489,940.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,489,940.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,489,940.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	822,500.00
210401	Бичиг хэрэг	469,500.00
210404	Ном, хэвлэл	353,000.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	332,440.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	332,440.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,335,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,489,940.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,489,940.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,929,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,700.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгө, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн аудитор О.Хосбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулав.

Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай, мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд оршино.

Байгууллага тайлангийн жилд дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаа. Үүнд:

Хүснэгт 1

/мян.төгрөг/

Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Ерөнхий боловсрол-71802	1,041,475,600	1,041,228,262	247,338
Насан туршийн боловсрол-71806	14,861,500	14,861,500	0,00
Дүн	1,056,337,100	1,056,089,762	247,338

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөний дагуу дүгнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1500 төгрөг”, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1800 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2021 оны 9 сарын 1-ээс 3,472 төгрөгөөр тогтоосныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж батлаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж батлаагүй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтаас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1084.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 17.3 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99.3 сая төгрөгөөр буюу 12,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	412.0	15.8	(396.1)
Бараа материал	207,705.9	297,754.3	90,048.3
Биет хөрөнгө	486,909.5	496,596.6	9,687.0
Биет бус хөрөнгө	78,863.0	78,863.0	0.00
<b>Нийт хөрөнгө</b>	<b>773,890.5</b>	<b>873,229.8</b>	<b>99.3</b>
Хуримтлагдсан үр дүн	(123,193.6)	171,742.7	294,952.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>773,890.5</b>	<b>873,229.8</b>	<b>100,524.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 90.1 сая төгрөгөөр өссөн. Өөрчлөлтөд материаллаг нөлөөлөл бүхий зардлууд:

- Тайлант онд худалдаж авсан 162.4 сая төгрөгийн бараа материал,
- Сумын ИТХ-ын 11 дүгээр тогтоолоор 5.0 сая төгрөгийн өвлийн спортын хэрэглэгдэхүүн,
- “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн санхүү менежментийн зөвлөхийн 2021 оны 6 сарын 04 ний өдрийн 2/28 тоот албан бичгээр 18.1 сая төгрөгийн СТЕМ хэрэглэгдэхүүний эд анги/ 1-2 -р анги/,
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 8 сарын 27-ны өдрийн А/390 захирамжаар 1.4 сая төгрөгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн материал,
- Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022 оны 1 сарын 14-ний өдрийн 27 тоот албан бичгээр БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар олгосон 65.1 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг бараа материал эрх шилжүүлэн хүлээн авсан.

Тайлант хугацаанд 297.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсан.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 9.7 сая төгрөгөөр өссөн. Үүнд материаллаг нөлөөлөл бүхий зардлууд:

- Тайлант онд байр шинээр ашиглалтад орсонтой холбогдож улсын төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 34,0 сая төгрөгийн сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, ном,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны А/97 тоот албан бичгээр 5.9 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны А/114 тоот албан бичгээр 17.7 сая төгрөгийн багш хөгжлийн төвийн тавилга тоног төхөөрөмж,
- БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар авсан 46.7 сая төгрөгийн хоол үйлдвэрлэл, сургуулийн тавилга тоног төхөөрөмжийг тус тус Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022 оны 27 тоот албан бичгээр эрх шилжүүлэн хүлээн авсан.

Мөн хугацаанд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 70-р тогтоолоор агуулах, хуучин хичээлийн байр, халуун усны байр, дотуур байр, хүүхэд хөгжлийн төв зэрэг 211.1 сая төгрөгийн барилга байгууламжийг акталсан.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй машин тоног төхөөрөмж 163.3 сая, тавилга хэрэгсэл 40.4 сая, бусад үндсэн хөрөнгө 29.5 сая нийт 233.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах арга хэмжээг 2021 онд авч хэрэгжүүлээгүй байна.

Биет бус хөрөнгийн үнийн дүнд өөрчлөлт ороогүй ба үүнд газар, программ хангамж бүртгэсэн байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 171.7 сая төгрөг болж өнгөрсөн оноос өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 21.8 сая төгрөг буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны гүйцэтгэлээс хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд буурснаас шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 966.4 сая, орон нутгийн төсвөөс 69.9 сая нийт 1,042.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сургуулийн 2021 оны анхны төсвийг Цагаан Үүр сумын ИТХ-ын 2020 оны 01 -р тогтоолоор баталсан бол тайлант хугацаанд төсөвт 1 удаа өөрчлөлт орж, төсвийг 100.4 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. Үүнд: төсөвт зардлын санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээс 88.6 сая, орон нутгийн төсвөөс 11.8 сая төгрөгөөр тус тус өсгөж нийт 1056.3 сая төгрөгөөр баталсан. Материаллаг зардлыг тодруулбал:

- Энэ онд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 65.4 сая төгрөг,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8.8 сая төгрөг,
- Хангамж, бараа материалын зардал 16.1 сая төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 0.3 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1.5 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2.3 сая төгрөг
- Нэг удаагийн шагнал урамшуулал 1.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Норматив зардал 13.9 сая төгрөг,
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 3.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант оны төсөв нэмэгдсэн шалтгаан нь ажилласан жилээс хамаарсан цалингийн шатлал, зэрэглэл өссөн, сургуулийн болон дотуур байрын барилга шинээр ашиглалтад орсонтой холбогдож үйлчилгээний ажилтан болон байр ашиглалтын зардал нэмэгдсэний дээр шинэ байрны тавилга хэрэгслийг Улаанбаатар хотоос өөрийн тээврээр татан авсантай холбогдож тээвэр шатахууны зардал өссөн. Харин норматив зардал буюу үдийн цайны зардал буурсан нь ковидын хөл хорионы улмаас танхимын сургалт буурсантай холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан нийт 1,056.3 сая төгрөг зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 980.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 76.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,056.1 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа ба цалин түүнтэй адилтгах зардал 0.24 сая төгрөг, дотоод албан томилолтын зардал 0.006 сая төгрөгөөр тус тус хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/54 тоот албан бичгээр түвшин тогтоох болон шалгалтын материал хувилах бичиг хэргийн зардал 0.3 сая, мөн газрын даргын 2021 оны А/45 тоот албан бичгээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс 4.3 сая, Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/40 тоот албан бичгээр ариутгал халдваргүйтгэлийн зардалд 0.33 сая, түрээсийн сурах бичгийн төлбөр 0.52 сая, тендерийн урамшуулал 0.04 сая төгрөг тус тус олгосныг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар танилцуулга ихээхэн дутуу байна. Үүнд шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилттой холбоотой мэдээлэл, санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсвийн гүйцэтгэлийн тайлбар танилцуулга, онцлох үйл явдлын тодруулга танилцуулга байхгүй байна. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал болох Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 0.24 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: цалин хөлс нэмэгдэл урамшил 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 576.4 сая төгрөгийн 46 мэдээллээс 396.4 сая төгрөгийн 44 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 180.0 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав.

Зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ихэр-мөрөн аудит ХХК нь 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаа гарсаар байгаагийн дээр төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг тогтвортой мөрдөж ажиллаагүй байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 233.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож цаашид ашиглах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Иймд өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллах

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан эсэхийг авч үзэх шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,223.0 сая төгрөгийн алдаа илэрснээс 989.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулж, үндсэн хөрөнгө болон дотоод хяналттай холбоотой 233.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж тус тус өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 989.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй бол.о

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Нягтлан бодох бүртгэл, тооцоололтой холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан нь тодруулга болон дэлгэрэнгүй бүртгэлтэй зөрсөн нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна. Мөн санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга, төсвийн гүйцэтгэлийн танилцуулга дутуу, онцлох үйл явдлын тухай мэдээллийг санхүүгийн тайланд тусгагдаагүй байгаа нь санхүүгийн тайлан иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл тооцоололтой холбогдсон алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх. УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4- дэх заалт,

Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу 3.20. УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх талаар хариуцлага хүлээсэн этгээд батлагдсан төсөв хэтрээгүй талаар мэдэгдэл гаргана. Хэрэв аливаа төсөвлөсөн дүн эсвэл аливаа батлагдсан төсвийн зориулалтаас хэтэрсэн, эсвэл батлагдсан төсөвгүй юмуу бусад эрх мэдлийн хэлбэрээр зардал гаргасан бол санхүүгийн тайланд тодруулга хийнэ" гэж заасны дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бүрэн гүйцэт толилуулах.

## **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

### **1.1 Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "тэг" үлдэгдэл өртөгтэй машин тоног төхөөрөмж 163.3 сая, тавилга хэрэгсэл 40.4 сая, бусад үндсэн хөрөнгө 29.5 сая төгрөг нийт 233.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган үнийг шинэчлэн тогтоож бүртгэлд тусгах гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө нийт 233.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. УСНББОУС-ын Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний загвар хэсэгт заасан удирдамж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

## **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

### **1.1 Илрүүлэлт:**

Байгууллага дотоод хяналтын журам заавар байхгүй, өмч хөрөнгийн бүртгэл тайлагнал, ашиглалт хамгаалалтад тавих хяналт сул байна.

### **1.2 Өгсөн зөвлөмж**

2022 онд дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан БАЙГУУЛЛАГЫН НЭР	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургууль	4	1,223.0	1	989.8	0	0	0	0	3	233.2